



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 19 өдөр

Дугаар A/213

Улаанбаатар хот

Өмч хамгаалах байнгын зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ашиглах хугацаа нь дууссан буюу ашиглах боломжгүй болсон засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг данс бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг хавсралтаар байгуулсугай.

2. Байгууллагын өмч хөрөнгийн бүрдэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөдөлгөөний байдалд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг хууль журмын дагуу хэрэгжүүлэн ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл /Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/268 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000651

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2021 оны 09 дугаар сарын 19 өдрийн
А/213 дугаар тушаалын хавсралт



Өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулах тухай

Зөвлөлийн дарга: Захиргаа Санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд: Өмчийн төлөөлөл менежментийн хэлтсийн мэргэжилтэн
Өмчийн мэдээлэл, хяналт ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Нягтлан бодогч